



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 555

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.3.7, 2018 оны 352 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баярплант ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ХААБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Баярплант ХААБ” ХХК /Б.Бямбасэлэм/-д үүрэг болгосугай.

3. “Баярплант ХААБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН